



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 12 сарын 24 өдөр

Дугаар 644

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах,
үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 3.2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Цагдаагийн ерөнхий газар, түүний харьяа байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглаж болох нийт 2725 нэр төрлийн 11,974,093,531.78 (арван нэгэн тэрбум есөн зуун далан дөрвөн сая ерэн гурван мянга таван зуун гучин нэгэн төгрөг далан найман мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг шинэчлэн хавсралтад заасны дагуу тогтоохыг зөвшөөрсүгэй.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Билгүүн, Цагдаагийн ерөнхий газрын дарга, цагдаагийн хурандаа С.Баатаржав болон тогтоолд заасан байгууллагын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасны дагуу хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД



0001286

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн
644 дугаар тогтоолын хавсралт

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР, ТҮҮНИЙ ХАРЬАА БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД
БҮРТГЭЛТЭЙ, ҮЛДЭГДЭЛ ӨРТӨГГҮЙ ХӨРӨНГИЙН АШИГЛАХ ХУГАЦААГ СУНГАХ,
ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ЖАГСААЛТ

Д/д	Байгууллагын нэр	Үндсэн хөрөнгийн дансны ангилал	Нийт нэр төрөл	Тоо хэмжээ	Нийт балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Шинэчлэн тогтоох нийт үнэ (төгрөг)	Цаашид ашиглах хугацаа (жилээр)
1	Хүч спортын хороо	машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил	62	110	52,275,036.73	25,256,420.00	2-3
2	Тээврийн цагдаагийн алба	машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, бусад	148	1230	1,906,402,685.00	387,679,300.99	2
3	Дотоодын цэргийн 805 дугаар анги	тээврийн хэрэгсэл, машин тоног, программ хангамж, тавилга, бусад	104	533	455,307,119.69	136,456,062.20	1-3
4	НХЖХ, ОНАБХА-ны Эрүүл хамгаалалтын газар	тээврийн хэрэгсэл, машин тоног, программ хангамж, тавилга, бусад	162	453.2	158,588,740.84	24,203,000.00	1.2
5	ЦДЦ-ын Сургалтын нэгдсэн төв	машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил	67	372	93,178,206.80	38,334,400.00	2-5
6	Автобааз	Авто тээврийн хэрэгсэл, машин тоног, тавилга эд хогшил, бусад	377	544	6,038,721,873.96	2,008,468,000.00	1-5
7	Эрүүгийн цагдаагийн алба	Машин тоног төхөөрөмж, тавилга, бусад, программ	286	850.8	426,937,740.52	218,631,936.84	2-5
8	Сүлд чуулга	Машин тоног төхөөрөмж, тавилга, программ	79	160	75,575,361.27	31,350,000.00	2-3

9	Тээврийн цагдаагийн албаны Төмөр зам дахь цагдаагийн газар	машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, бусад	85	204	76,990,947.42	39,252,572.00	1-5
10	Дотоодын цэргийн 05 дугаар анги	тээврийн хэрэгсэл, машин тоног, программ хангамж, тавилга, бусад	220	1254	479,038,875.03	208,948,747.00	2-4
11	Хангалт үйлчилгээний төв	машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, бусад, программ	70	104	55,658,201.57	38,764,885.18	1-3
12	Захиргааны удирдлагын газар	машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, бусад, программ	702	1748.9	1,286,490,496.34	389,838,042.85	2-3
13	Мэдээлэл дүн шинжилгээ шуурхай удирдлагын алба	тээврийн хэрэгсэл, машин тоног, программ хангамж, тавилга, бусад	130	209	453,077,687.86	125,310,000.00	2-10
14	Мөрдөн байцаах алба	машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, программ	54	117	80,442,698.29	47,850,000.00	2-5
15	Сүүж-уул амралт сэргээн засах сувилал	тээврийн хэрэгсэл, машин тоног, программ хангамж, тавилга, бусад	258	1246.1	335,407,860.49	58,155,396.33	2-5
	Нийт дүн		2725	9136	11,974,093,531.81	3,778,498,763.39	